



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 27 өдөр

Дугаар A/05

Хэрлэнбаян-Улаан тосгон

**Хүүхэд хамгааллын багийн бүрэлдэхүүн
томилох тухай**

Монгол Улсын “Хот-тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн 6, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29 дүгээр заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэнбаян-Улаан тосгоны “Хүүхэд хамгааллын баг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Багийн ахлагч:	Б.Энхцэцэг – Тосгоны захирагч
Нарийн бичгийн дарга:	Б.Энхсаруул – Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Гишүүд:	Н.Мөнхтуяа – Эрхлэгч их эмч
	М.Хүүхнээ – Цэцэрлэгийн эрхлэгч
	Д.Солонго – Сургуулийн захирал
	Б.Хангай – Хэсгийн төлөөлөгч
	С.Отгонбаяр – Захирагчийн ажлын албаны дарга

2. Тус тосгоны хүүхэд нэг бүрийг сургууль, цэцэрлэг, дотуур байр, гэр бүлийн орчинд бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны болон үе тэнгийн дарамт, гэмт хэрэг зөрчилд хохирогч болон холбогдогч болгохоос урьдчилан сэргийлэх, хорт зуршилд өртүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлэн зохион байгуулж ажиллахыг хүүхэд хамгааллын багт даалгасугай.

3. Хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, бодлого хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллаж ажиллагааны явцыг эцэг эх, асран хамгаалагч, багш ажилчид, сурагчдад тайлагнаж байх, жилийн эцсийн хийсэн ажлын тайланг нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Энхсаруул) -д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ